

ТЕНДЕР ИРҮҮЛЭХИЙН ӨМНӨХ УУЛЗАЛТ ХИЙСЭН ТУХАЙ
ТЭМДЭГЛЭЛ
№ 01

2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240101476 дугаартай “Цанхийн баруун уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт хийх” /Багц-4/гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичгийн ТШЗ 10.1-д заасны дагуу 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 15:00 цагт тендерийн өмнөх уулзалтыг хийхээр товлосон ба zoom meeting ID 4102035897 хаягаар тус уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад тендерт оролцохыг сонирхогч 2 хуулийн этгээд, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөл 3 хүн, нийт 5 хүн оролцлоо.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Тендерийн баримт бичигтэй холбоотой тайлбар, ажлын даалгавар танилцуулах;
2. Тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тендерийн баримт бичигтэй холбоотой нэмэлт тодруулгад хариулт, мэдээлэл өгөх;

СОНССОН НЬ:

“Эрдэнэс Тавантолгой”: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан Цанхийн баруун уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичгийн ТШЗ-10.1-д заасны дагуу тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг хийж байна.

Уг уулзалтад оролцохдоо камерийн дүрсээ өгч, компанийн нэрээ тодорхой бичиж оролцохыг анхаарна уу. Хэрэв нэр, дүрсгүй уулзалтад хүсэлт илгээвэл оролцох боломжгүй гэдгийг анхаараарай.

Ажлын даалгаврын дэлгэрэнгүйг ТББ-т дэлгэрэнгүй оруулсан. Гүйцэтгэгчид тавигдах шаардлагын хувьд нийтдээ 3 жилийн хугацаанд 16 сая куб метр уулын ажлыг гүйцэтгэнэ. Тоног төхөөрөмжийн хувьд тендерийн баримт бичиг болон ажлын даалгаварт заасан А.буюу Ухаж ачих, тээвэрлэх техникүүдийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. Автосамосвалуудын хувьд нийлбэр даац 4,750 тн-оос багагүй байх гэж заасан. Дээрх машин механизмын эзэмшигч, даацын талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан Авто тээврийн үндэсний төвийн мэдээллийн сангаас лавлана Даацыг АТУТ-ийн систем дэх даац гэсэн үзүүлэлтээр тооцох бөгөөд бүх жин, өөрийн жин гэсэн үзүүлэлт хамаарахгүй. Санал болгож буй машин механизмын мэдээлэл үнэн зөв, бодит байдлаас зөрүүтэй бүртгэгдсэн аливаа асуудал нь захиалагч хариуцлага хүлээхгүй бөгөөд төрийн анхдагч өгөгдөл хадгалж буй мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн үнэлгээг хийх болохыг анхаарна уу гэж тодорхой заасан.

В.Уулын туслах техник, тоног төхөөрөмжүүдийг ажил эхлэх үед уурхайд бэлэн байлгах үүргийг хүлээнэ. Үнэлгээнд харгалзахгүй.

С.Ухаж ачих , тээвэрлэх техникүүдийг хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын 2 дахь жилээс эхлэн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн ажиллуулах үүрэг хүлээх тухай баталгааг албан бичгээр гарган ирүүлнэ гэж заасан.

Техникийн үзүүлэлтүүдийг үйлдвэрлэгчийн албан ёсны танилцуулга болон вэб сайтаас давхар нягтлан шалгах болно.

Ажиллах хүчний хувьд тендерт үнэлэх хүний нөөцийн мэдээллийг тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д зааснаар үнэлнэ. Мэргэжлийн хувьд уул уурхайн чиглэлээр нэлээд өргөн цар хүрээтэй шаардсан ба хязгаарлсан зүйл байхгүй. Гүйцэтгэгчийн хувьд 3-аас доошгүй жил уул уурхайн салбарт хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил, эсхүл түүнтэй дүйцэх уулын ажил хийж гүйцэтгэсэн байх шаардлага тавьсан.

Асуулт: Ажил гүйцэтгэхэд шаардагдах техник хэрэгсэл нь зээлийн эсхүл фидуцийн гэрээтэй байж болох уу? Гэрээг бүгдийг хавсарган ирүүлэх шаардлагатай юу?

Хариулт: Уулын ажлыг гүйцэтгэх гол үндсэн техник болох А хэсэгт өөрийн эзэмшлийн байхаар заасан техникийн эзэмшигчийн мэдээллийг ТББ-т заасан хувь хэмжээгээр шалгана. Түрээсийн гэрээгээр санал болговол түрээслэгч нь эцсийн өмчлөгч мөн эсэхийг шалгана. Лизингээр авсан техник байгаа бол АТҮТ-ийн систем дэх бүртгэлийн мэдээллээ шалгаад тендерт оролцогчийн нэрээр бүртгэгдсэн байгаа эсэхийг шалгаж нягтлах шаардлагатайг анхаарна уу. Гэрээг бүгдийг хавсарган ирүүлнэ.

Асуулт: Арилжааны банкны судлагдсан зээл авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт гэдэгт банк бус санхүүгийн байгууллагын судалж үзээд зээл олгох боломжтой шийдвэр байж болох уу?

Хариулт: ТББ-ын 18.1-д:

Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтийн аль нэгээр, эсхүл нийлбэрээр тодорхойлно. Үүнд:

- Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл;
- Арилжааны банкны судлагдсан зээл авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /судалж үзээд зээл олгох боломжтой тухай тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй./;
- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд гэж тухайлан заасан.

Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

Асуулт: Одоо Баруун Цанхи дээр уулын ажлын туслан гүйцэтгэгчээр өөрийн техник, боловсон хүчнээ ашиглан ажиллаж байгаа компани тендерт дахин оролцож болох уу? Болно гэвэл техникээ давхцуулан мэдүүлж болох уу?

Хариулт: Тендерт оролцох эрх нь нээлттэй. Хүний нөөц болон техникийн давхацлыг нэгбүрчлэн хянан үзэж үнэлгээнд харгалзана.

Тендерт оролцохыг сонирхогч этгээдээс асуулт байхгүй гэв.

“Эрдэнэс Тавантолгой” ХК: Асуулт байхгүй бол уулзалтыг дуусгая. Нэмэлт тодруулах зүйл байвал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу заасан хугацаанд албан бичгээр цахим системийн холбогдох талбарт оруулж болно. Уулзалтад оролцсонд баярлалаа. Амжилт хүсье гэснээр уулзалт 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 15:30 цагт дууслаа.

